



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

МЭДЭЭ

№205 /415/

2022.11.14

Цаг үе, үйл явдал

ЦЭРГИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ 30 ЖИЛИЙН ХӨГЖЛИЙГ ТОДОРХОЙЛСОН ЦЭРГИЙН ЭРДЭМТЭД ЧУУЛЛАА



Үндэсний Аюулгүй байдлын зөвлөл, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб, Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Хил хамгаалах ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газрын төлөөлөл, эрдэмтэн доктор профессорууд чуулсан "Цэргийн эрдэмтдийг Монгол Улсад бэлтгэж эхэлсний 30 жил-цэргийн шинжлэх ухааны хөгжил" сэдэвт эрдэм шинжилгээний хурал боллоо.

Хурлыг нээж Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай хэлсэн үгэндээ: "Монгол Улсад цэргийн эрдэмтэн бэлтгэж эхэлсний 30 жилийн ойн баярын мэндийг өргөн дэвшүүлье. Монгол Улс анхны цэргийн эрдэмтнийг ЗХУ-д бэлтгэснээс хойш даруй 62 жил өнгөрчээ. 1960-1990-ээд он хүртэл ЗХУ-д бэлтгэгдсэн цэргийн эрдэмтэд Цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэх үндэс, суурийг тавьж, улмаар дотооддоо цэргийн эрдэмтдийг бэлтгэх үйлсэд хүчин зүтгэсэн гавьяатай хүмүүс гэж үздэг. Өнөөдөр ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын алба нь цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах судлал, аюулгүй байдал судлал чиглэлээр докторын сургалтыг явуулж, өнгөрсөн 30 жилийн хугацаанд цэргийн эрдэмтдээс "Ардын багш", "Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн", "Гавьяат багш" нар олноор төрөн гарсны зэрэгцээ өнөөдөр шинжлэх ухааны 14 доктор, боловсролын 200 гаруй доктортой болоод байна. "Батлан хамгаалах судлал, цэргийн шинжлэх ухаан, технологи, инновацыг 2030 он хүртэл хөгжүүлэх бодлого"

баримт бичигт тусгагдсан ҮБХИС-ийн бүтцэд ахисан түвшний "Эрдмийн сургууль" байгуулах асуудлыг Батлан хамгаалахын сайдын зөвлөлийн хуралдаанаар шийдвэрлэснийг та бүхэнд дуулгахад таатай байна. Өнөөдрийн эрдэм шинжилгээний хурлаар цэрэг, батлан хамгаалах, аюулгүй байдлын судалгаа хөгжүүлэлтийн ажлыг цэгцтэй болгох, нэгдсэн ойлголтод хүрэх, цэргийн шинжлэх ухаан, аюулгүй байдал, батлан хамгаалах, хил, гамшиг судлалын хоорондын уялдаа холбоог хангах, залуу эрдэмтдийг бэлтгэх зэрэг асуудлыг олон талын өнцгөөс харсан, санаа бодлоо солилцсон, үр дүнтэй хурал болно гэдэгт эргэлзэхгүй байна. Мөн Монгол Улсын шинжлэх ухаанд батлан хамгаалах салбарын шинжлэх ухааны эзлэх байр суурийг бэхжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замыг эрдэмтэн, судлаачдын дунд хэлэлцүүлж, цаашид өргөжүүлэн хөгжүүлэхэд онол, арга зүйн хувьд дэмжлэг үзүүлэхийг бүтээлч санал, зөвлөмж гарна гэдэгт итгэл дүүрэн байна. Эрдэм шинжилгээ, судалгааны ажил бол хүн бүхний хийж чаддаг амар ажил биш. Улс орны хөгжил, дэвшлийн суурь нь эрдэм шинжилгээ, судалгаа байдаг. Та бүхний Монгол Улсынхаа Цэргийн шинжлэх ухаан, боловсролын үйлсэд оруулж буй үнэтэй хувь нэмэрт талархахын сацуу цаашдын ажил хөдөлмөрийн дэвшил хөгжилд итгэж амжилтын дээдийг хүсэн ерөөе" хэмээсэн юм.

Эрдэм шинжилгээний хурлын үндсэн

илтгэгчээр ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын албаны профессорын багийн ахлагч, доктор профессор, хурандаа Л.Батцэнгэл "Үндэсний цэргийн эрдэмтэн бэлтгэж ирсэн түүхэн уламжлал" сэдвээр илтгэл тавьсан бол хавсралт илтгэгчээр ҮАБЗ-ийн Ажлын албаны дэд дарга, Стратегийн бодлого, дүн шинжилгээ, мэдээллийн газрын дарга, хурандаа Д.Мөнх-Очир, ҮБХИС-ийн Эрдэм шинжилгээ нийгмийн түншлэл хариуцсан дэд захирал, доктор, профессор, хурандаа Б.Өлзийхуяг, хошууч генерал С.Баасанхүү, БХЭШХ-ийн Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор, хурандаа Ш.Паламдорж, хошууч генерал О.Уржин, ҮБХИС-ийн Ахисан түвшний сургалтын албаны профессор, Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн, доктор, профессор, хошууч генерал Б.Эрдэнэбат, Стратегийн судалгааны хүрээлэнгийн Цэрэг, стратегийн судалгааны төвийн дарга, доктор, профессор, хошууч генерал З.Болдбаатар, ЭШНХ-ийн Хилийн аюулгүй байдал судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, доктор, профессор, хурандаа Ц.Ганболд, Гамшиг судлалын хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, дэд хурандаа П.Чимэдцэрэн нар илтгэл хэлэлцүүлсэн юм.

Х.УНДАРМАА

БҮЖГИЙН СЕКЦ ЯВУУЛЖ БАЙНА



Хувьсгалт тэмцлийн зорилгоор 7 хоног бүрийн нэг ахмад зүтгэлтэн хурандаа О.Сэрдариин нэрэмжит сэтгэл зүйг өргөх өдөр болгон Цэргийн гавьяаны улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 015 дугаар анги шинэ сургуулийн жилийн сэтгэл зүйн хангалтын төлөвлөгөөний дагуу алба хаагчдыг хөгжүүлэх, олон нийтийн ажилд идэвхтэй хамруулах, авьяас, ур чадварыг хөгжүүлэх зорилгоор бүжгийн секц, ширээний теннис, шатар, даамны дугуйланг хичээллүүлж эхэллээ. Алба хаагчдад урлагаар дамжуулан гоо зүйн хүмүүжил олгож, эрүүл аргаар биеийн зохистой харьцаа бүрдүүлэхийн зэрэгцээ хамт олны дунд эерэг уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор 7 хоног бүрийн нэг өдрийг бие бүрэлдэхүүний сэтгэл зүйг өргөх өдөр болгон зарласан юм. Уг үйл ажиллагааны хүрээнд ЦДБЭЧ-ын бүжгийн багш н.Дамбыг урьж "Заавал сурах 10 бүжиг"-ийг 11 дүгээр сард бие бүрэлдэхүүнд заахаар төлөвлөөд байна. Одоогоор алба хаагчдад "Гурван тамирын уянга", "Жаахан Дулмаа", "Удаан вальс" зэрэг бүжгийг зааж сургасан бөгөөд цаашид "Чардаш", "Сургуулийн вальс", "Венгерка" буюу цэргийн марш, "Полька", "Ёохор", "Хүмүүн төрөлхтөн", "Задгай цагаан", "Румбо" зэрэг нийтийн цэнгээнт бүжгийг зааж сургахаар ажиллаж байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 0	☁️ -13

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 38	☁️ 23

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,435	3,445
EUR 🇪🇺	3,520	3,550
CNY 🇨🇳	480	482
RUB 🇷🇺	53.70	54
JPY 🇯🇵	24.30	24.60
KRW 🇰🇷	2.61	2.65

ЗУРХАЙ



2022.11.14 / ДАВАА ГАРАГ /
БИЛГИЙН ТООЛЛЫН 21

НАМРЫН АДАГ ЦАГААН НОХОЙ САР
ЕСӨН УЛААН МЭНГЭТЭЙ ЦАГААГЧИН ХОНЬ ӨДӨР

Үс засуулбал:

Өвчин ирнэ

Наран ургах, шингэх:

07.52-17.20

Барилдлага:

Үхэх

Шүтэн барилдлага:

Төрөн түгэхүй

Тухайн өдөр нохой, хонь жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Эл өдөр амь таслах, хор найруулах үйлнээ зэрэгчлэн бүтнэ, хувцас хийх, гэр орон барих, сан нуун дарахад сайн. Зүүн нүд татвал эцэг, эх садны хэрэг бүтэх баруун нүд татвал эд олох, зүүн чих хангинавал аймшиг болох, баруун чих хангинавал хэрүүл тэмцэл болох, хэрээ дуугарвал зочид ирэх, тагнай загатнавал сэтгэл зовох, бүх бие татвал хэрэг олон болох, хөл татвал үзэсгэлэн болно.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 640,386,940

Эдгэрсэн

Нийт: 620,096,996

Нас барсан

Нийт: 6,615,538

СЭТГЭЛ ЗҮЙ БА БИДНИЙ МАНЛАЙЛАЛ...



ЭРҮҮЛ МЭНД, СЭТГЭЛ ЗҮЙН ТАСАГ 55 ХҮНИЙ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ

ЦЕГ-ын Дотоод хяналт аюулгүй байдлын газрын эрүүл мэнд, сэтгэл зүйн тасгийн ахлах сэтгэл зүйч цагдаагийн хошууч Э.НОМИНЖАРГАЛ:

-Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилдэг 800 гаруй хууль байдаг бөгөөд үүний талаас илүү нь цагдаа, дотоодын цэргийн үйл ажиллагаанд чиг үүрэг болгох байдлаар зохицуулсан байдаг.

Тухайлбал захиргааны үүрэг гүйцэтгэлд 12000 гаруй алба хаагч үүрэг

гүйцэтгэж байна. Иймд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын хувьд алба хаагчдын сэтгэл зүйн тогтвортой байдлыг хангах, сэтгэл зүйн эрүүл мэндийн өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэнд, сэтгэл зүйн тасгийг 55 хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулж өдгөө үйл ажиллагаа тогтвортой явуулж байна. Тус чуулга уулзалтаар бусад байгууллагуудаасаа харилцан туршлага судалж, шинэлэг инновац болохуйц олон зүйлийг мэдэж авсны зэрэгцээ хүний нөөцийн талаар хамтран ажиллах боломж бололцоо байгааг харлаа.



ОЛОН ШИНЭЛЭГ САНАА, ШИЙДЛҮҮД УРГАН ГАРСАН ҮР ДҮНТЭЙ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЖ ӨНДӨРЛӨӨ

Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн сэтгэл зүйн хангалтын офицер дэслэгч Б.ЁНДОН:

-Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын сэтгэл зүйчдийн нэгдсэн чуулга уулзалт анх удаа зохион байгуулагдлаа. Бид тус чуулга

уулзалтаар цаашдаа хийж хэрэгжүүлэх ажил, төсөл хөтөлбөрүүдэд хэрхэн хамтарч ажиллах, ямар баримт бичигт тулгуурлах вэ гэдэг талаар түлхүү санал солилцлоо.

Зэвсэгт хүчний хувьд байлдааны бэлэн байдал, сургалт дадлагад чиглэгдсэн сэтгэл зүйн сургалтыг тасралтгүй зохион байгуулдаг.

Мөн ирээдүйд илүү өргөн хүрээгээр цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн эрүүл мэндийг дэмжих зорилгоор олон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр зорин ажиллаж байна.

Анх удаагийн нэгдсэн уулзалт хэдий боловч олон шинэлэг санаа, шийдлүүд урган гарсан үр дүнтэй хэлэлцүүлэг болж өндөрлөв. Ирэх жилийн чуулга уулзалтын хувьд хэлэлцэж буй асуудал, хийж хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө улам боловсронгуй болохын зэрэгцээ оролцох бүрэлдэхүүний тоо, хамрах цар хүрээ ч улам бүр хүрээгээ тэлнэ байх гэж бодож байна.

Ө.НАСАНТОГТОХ

СЭТГЭЛ ЗҮЙН БЭЛТГЭЖИЛТИЙН СТАНДАРТЫГ ХАНГАСАН ТОХИОЛДОЛД ЦЭРГИЙН АЛБА ХААДАГ ТОГТОЛЦООНД ШИЛЖИХ ХЭРЭГТЭЙ

Хил хамгаалах Ерөнхий газрын сэтгэл зүй хангалтын хэлтсийн дарга дэд хурандаа Б.ЦЭДЭНДОРЖ:

-Юуны өмнө "Сэтгэл зүй ба бидний манлайлал" сэдэвт чуулга уулзалтыг зохион байгуулсан ЗХЖШ-ын СБГ-ын хамт олонд талархал илэрхийлье. Тус чуулга уулзалтад уригдаж туршлага, санал зөвлөмжөө хуваалцах боломж олдсонд бид баяртай байна.

Хил хамгаалах байгууллага 2022 онд сэтгэл зүй, соён гэгээрүүлэх чиглэлд хийж хэрэгжүүлсэн болоод хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээгээ чуулга уулзалтад оролцогчдод тайлагнахын зэрэгцээ бусад байгууллагуудаасаа туршлага судаллаа.

Хил хамгаалах байгууллага 2018 оноос цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэлжилтийн стандартыг бий болгох зорилго зорилтыг дэвшүүлэн ажиллаж байна. Жишээлбэл тухайн хүн бие бялдрын шалгуур үзүүлэлтийг хангасан тохиолдолд цэргийн албанд тэнцэж алба хаах эрх үүсдэг. Үүнтэй адил сэтгэл зүйн бэлтгэлжилтийн стандартыг хангасан тохиолдолд цэргийн алба хаадаг тогтолцоонд шилжих хэрэгтэй. Сэтгэл зүйн бэлтгэлжилттэй хүн цэргийн албанд орох ёстой гэдэг боловч энэ нь бодитоор хэрэгждэггүй. Ийм учраас манай байгууллагаас холбогдох ажлын хэсэг байгуулж

судалгаа шинжилгээний ажлыг хийж байна.

Хурлын үеэр тус асуудлыг нийтийн дунд хэлэлцүүлж бусад байгууллагууд хамтран ажиллах санал хүсэлтээ илэрхийллээ. Бидний хувьд ч мөн адил нэгэнт цэргийн алба хаагчдын сэтгэл зүйн бэлтгэлжилтийн стандартыг тогтооно гэсэн зорилгыг дэвшүүлэн ажиллаж буй учир зөвхөн хилийн цэрэг гэж явцуурах бодолгүй байна.

Мөн байгууллагуудын дунд ижил төрлийн судалгааг хоёр талд судлах байдлаар цаг хугацаа, хөрөнгө, мөнгө, хүн, хүч зарлагад байдлыг зогсоож нэгдмэл байдлаар ажиллах талаар санал хүсэлтээ солилцлоо.

Төрийн цэргийн болох хууль сахиулах байгууллагуудын сэтгэл зүйчид урьд өмнө ийм өргөн хүрээний ажил хэрэгч уулзалтыг зохион байгуулж байсангүй. Бидний хувьд сэтгэгдэл маш өндөр байна. Хэнд ямар ажил хэрэгч санаа, туршлага, зөвлөмж байгаагаа харах юмсан, хэлэлцэх юмсан гэсэн бодол байсан нь өнөөдөр биеллээ оллоо. Мөн ирэх жил Хил хамгаалах байгууллагын 90 жилийн ойн хүрээнд тус чуулга уулзалтыг уламжлал болгон явуулах зарчмаар зохион байгуулах саналаа илэрхийллээ.

Ямартай ч энэ удаагийн хурлаар бүгд нэгнээ таньдаг болохоос эхлүүлээд ямар төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх вэ гэдэг хүртлээ ярилцаж зөвлөлдлөө. Ирэх жилийн уулзалтаар ямар үр дүн гаргасан бэ, хэн ямар ажил хийж хэрэгжүүлсэн бэ гэдгээ тайлагнасан хурал байх болно гэдэгт итгэлтэй байна.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 016 ДУГААР НЭГТГЭЛД...



АНХНЫ БУУДЛАГА АМЖИЛТТАЙ

Энэ оны II ээлжээр үеэр байлдагч О.Өсөхбаяр, хугацаат цэргийн албанд Д.Дандар, Э.Мөнх-татагдсан дайчид цэргийн Очир, Н.Амин-Эрдэнэ, анхан шатны бэлтгэл С.Эрдэнэтөгөлдөр нарын сургалтад амжилттай тэргүүтэй 13 хугацаат цэргийн хамрагдаж автоматын анхны алба хаагч онц буудаж дасгал боловсрууллаа. Энэ бусдыгаа манлайлав.



СОЁЛЫН БҮТЭЭЛЧ САР АЯНЫ ХҮРЭЭНД...

Төв аймгийн Соёл найрагч Ш.Цэрэндоо нар тус урлагийн газраас зохион нэгтгэлийн хугацаат цэргийн байгуулж буй "Соёлын алба хаагчдад соёлын үнэт бүтээлч сар" аяны хүрээнд аймгийн Соёл урлагийн мэдээлэл, яриа таниулга, газрын дарга Б.Тунгалаг болон төрийн захиргааны сурталчилгааны ажлыг зохион ахмад ажилтан МУУГЗ, яруу байгуулав.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ

ЗАРЛАЛ

БАРИМТАТ ГЭРЭЛ ЗУРГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго: Нэгдсэн Үндэсний Байгууллагаас зарласан Авлигын эсрэг олон улсын өдийг угтан дэлхийн улс орнууд Авлигын эсрэг конвенциар хүлээн зоригжиж хэрэгжилтийг сурталчлах, хүүхэд, залуучуудад авлигыг үл тэвчих, шударга ёсны үзлийг төлөвшүүлэх, авлигын нийгэм, эдийн засгийн хор хөнөөлийг тайлбарлан таниулах, авлигын эсрэг үйлдэл дуу хоолойгоо нэгтгэн, олон нийтийн дуу хоолойг сонсох, хүсэл зориогоо илэрхийлэх боломжийг бүрдүүлэх.

Хоёр. Зохион байгуулагч: Авлигатай тэмцэх газар Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтэс, Монголын гэрэл зургийн нэгдсэн холбоотой хамтран ажиллана.

Гурав. Бүтээлийг ирүүлэх, хүлээн авах хугацаа, хаяг: 2022 оны 11 дугаар сарын 01-15 ны өдөр хүртэл Авлигатай тэмцэх газрын Олон нийтийн тав байранд болон iaavphoto.mpa22@gmail.com цахим хаягаар хүлээж авна.

Дөрөв. Сэдэв: "Авлигын хор хөнөөл, иргэдийн харах өнцөг", "Авлигын эсрэг таны оролцоо", "Авлигын эсрэг хөтөлбөр", "Авлига ба хуульчилсан иргэд", "Авлигын хор хөнөөл, таны бодлоор", "Авлига хөгжлийн эсрэг когт үйлдэл", "Авлига улс үндэстний эмгэнэл", "Авлигатай нийгмийг хамтдаа үлдээе", "Авлигын сүүдэр", "Авлига ба Үндэстний мөхөл", "Авлигыг үл тэвчье", "Авлига аюул мангас".

Тав. Тавигдах шаардлага: Бүтээл нь уран сэтгэмж бодит нөхцөл байдлаар тулгуурлан бүтээгдсэн байх, Баримтат гэрэл зураг нь авлигын хор хөнөөлийн утга санааг тусгасан байх, Ном, сэтгүүл, сурах бичиг болон эх үүсвэрээс хуульбарлагүй байх, Хувь хүний нууц болон бусдын нэр хүндийг гутан доромжилсон агуулгагүй, Улс төрийн агуулгагүй байх, Тусгай технологи (фотошоп програм г.м) агууллага, монтаж илгэд ашиглахгүй байх. Нэг уран бүтээлч 3-5 хүртэл бүтээлээр оролцох боломжтой ба сэдэв, тайлбар, бүтээл гаргасан эмний нэр, цахим шуудан, утасны дугаар зэрэг мэдээллийг тусгах, 30см x 20см DPI 300 хэмжээтэй бэлтгэж, JPEG форматтай байна.

Зургаа. Бүтээлийн шалгаруулалт: Эхний шалгаруулалтыг 2022 оны 11 дугаар сарын 25-ны дотор явуулна. Хоёр дахь шалгаруулалтыг 2022 оны 12 дугаар сарын 01-ны дотор явуулна. Дүнг 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн Авлигын эсрэг олон улсын өдийг тохиолдуулан зохион байгуулах арга хэмжээнд үзэсгэлэн гаргаж, олон нийтэд толилуулана.

Долоо. Шагнал: III байр эзлүүлж мөнгөн шагналаар шагнана

110
Авлигыг мэдээлэх утас